

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ

2008 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 30
хот

Улаанбаатар

Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих тухай

"Төрийн бус байгууллагын тухай хууль"-ийн 9 дүгээр зүйл, "Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-ийн 32 дугаар зүйл, "Монгол Улсын Засгийн газрын тухай хууль"-ийн 19 дүгээр зүйл, "Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн 22 дугаар зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгаль орчны төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийг өргөн оролцуулах, байгаль орчны мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлын цар хүрээг өргөжүүлэх зорилгоор төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих орон тооны бус зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, үйл ажиллагааны чиглэлийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2008 оныг байгаль орчныг хамгаалахад Төрийн бус байгууллагын оролцоог дээшлүүлэх жил болгон зарлаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

2.1. Төрийн Бус байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын жагсаалтыг сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, шаардлагатай зардлыг санхүүжүүлэхтэй холбогдсон арга хэмжээг зохих журмын дагуу зохион байгуулахыг газар, хэлтэс, агентлагийн дарга нарт даалгасугай.

2.2 Байгаль орчны төрийн бус байгууллагуудын улсын зөвлөлгөөнийг 2008 оны 4 дүгээр улиралд зохион байгуулж ажлын арга туршлагыг нь дэлгэрүүлэх, мэдээлэл солилцох, үйл ажиллагааны уялдаа холбоо, үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авахыг төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих орон тооны бус зөвлөлд даалгасугай.

3. Төрийн бус байгууллагын талаар Байгаль орчны яамнаас баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, ажлын арга туршлага, үр дүн, зөвлөлгөөн угтсан ажлын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс /Д.Дагвадорж/-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Төрийн бус байгууллагыг дэмжих тухай" Байгаль орчны сайдын 1999 оны 12 дугаар сарын 06 ны өдрийн 148 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА

**Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих орон тооны бус зөвлөлийн
бүрэлдэхүүн**

Зөвлөлийн дарга: Төрийн нарийн бичгийн дарга

Орлогч дарга: Монголын байгаль орчныг хамгаалах холбооны тэргүүн

Гишүүд: Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн газрын дарга, Байгаль хамгаалах сангийн тэргүүн

ТХГН-ийн удирдлагын газрын дарга

Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн газрын дарга

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Ойн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга

Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны хэрэг эрхлэх газрын дарга

Нийслэлийн байгаль орчныг хамгаалах газрын дарга

“Мөнх ногоон амьдрал” төрийн бус байгууллагын тэргүүн

“Байгаль 21” төрийн бус байгууллагын тэргүүн

Нарийн бичгийн дарга: Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн
/Төрийн бус байгууллагын асуудал хариуцсан /

Байгаль орчны сайдын 2008 оны 30 тоот тушаалын 2 дугаар хавсралт

**Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг
дэмжих орон тооны бус зөвлөлийн
үйл ажиллагааны чиглэл**

1. Зөвлөл нь байгаль орчны талаар төр, засгийн газраас дэвшүүлсэн зорилт, чиглэлийг хэрэгжүүлэхэд байгаль орчны төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах арга хэмжээг тэдгээрийн санал, хүсэлт болон боломжид тулгуурлан зохион байгуулна.
2. Зөвлөл нь байгаль орчны төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг өргөжүүлэх үе шаттай төлөвлөгөө батлан биелэлтэд нь байнгын хяналт тавьж ажиллана.
3. Зөвлөл нь байгаль орчны төрийн бус байгууллагуудаас БОЯ болон холбогдох байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хэрэгжүүлсэн ажлын тайланд үнэлэлт өгч, жилийн ажлын нэгдсэн дүнг Байгаль орчны сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулж байна.
4. Зөвлөл нь Байгаль орчны яам, агентлаг, газар, хэлтсүүд болон байгаль орчны төрийн бус байгууллагуудын төлөөлөгчдийн уулзалтыг жилд хоёроос доошгүй удаа зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох арга замыг зөвшилцөж байна.
5. Зөвлөл нь байгаль орчны төрийн бус байгууллагуудын боловсруулсан төслүүд болон төлөвлөсөн

арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг дотоод, гадаадын санхүүгийн боломжийг ашиглан шийдвэрлэж дэмжлэг үзүүлж байна.

6. Зөвлөл нь Засгийн газар, Байгаль орчны яам, агентлагууд болон холбогдох байгууллагуудаас эрхлэн гаргасан байгаль орчны хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай гарын авлага болон мэдээллийг байгаль орчны төрийн бус байгууллагуудад хүргэнэ.

7. Зөвлөл нь "Засгийн газрын тухай" хуулийн 19 дүгээр зүйл, "Монгол улсын яамны эрхзүйн байдлын тухай" хуулийн 22.5.д заасны дагуу төрийн тодорхой ажил, үүргийг байгаль орчны төрийн бус байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх тогтолцоог буй болгож, шаардагдах зардлыг байгаль хамгаалах сангаас санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавина.

8. Зөвлөл нь байгаль орчны хууль тогтоомж, шийдвэрүүдийг шинээр боловсруулах боловсронгуй болгох зорилгоор байгуулагдах ажлын хэсгүүдэд байгаль орчны холбогдох төрийн бус байгууллагуудын төлөөлөгчдийг оролцуулан олон нийтийн саналыг тусгах боломжийг бий болгон ажиллана.

9. Байгаль орчны төрийн бус байгууллагуудын гадаад харилцаанд дэмжлэг үзүүлэх үүднээс олон улсын ижил төстэй байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллахад нь дэмжлэг туслалцаа үзүүлнэ.